

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Жамьян	Дугаар	L024
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Сүхбаатар дүүрэг
Төрсөн газар	Сэлэнгэ аймгийн Хүйтэн Шарын гол	Төрсөн он	1917
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Жасын аймаг, Дашчоймбол дацан	Сүм хийдийн дугаар	UBNR 942
Одоогийн сүм хийд	Дашчойлин хийд	Сүм хийдийн дугаар	UB 02
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 17	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан

### Их хүрээний Жасын аймаг, Дашчоймбол дацан

Би 5 настай Ганданд сууж 8 настай уншлага төгсгөж Дашчоймболд хүрж эхэлсэн. Жасын аймаг гэдэг аймагт аймаглаад тэгээд Дашчоймбол дацанд орсон. Заавал аймагтай байх ёстой. Аймаг гэдэг нь анхны хийд юм. Тэндээсээ аль нэг дацанд ордог байсан. Одоо манайх гаарамбын зиндаанд явж байна.

Дашчоймболын гол сахиус нь Гомбо, гол ядам нь Жигжид.

Хойд дацан Чойжоо сахиустай, Баруун дацангийн сахиус нь Лхам байсан. 3 гол сахиусыг ингэж тахидаг байсан. Дашчоймболыг 5000-аад ламтай гэж байсан. Их олон. Тэндээс эндээс сууна гэсэн юм байхгүй хүрээ 30 аймгаас, мөн хөдөөнөөс ирж суудаг байсан.

Хүрээнд 30 аймаг, 10 дацан байсан. Аймгуудын нэрс нь

1. Шүтээний аймаг
2. Дондовлин аймаг
3. Жиддаран аймаг
4. Даштойсомлин аймаг
5. Дүйнхорын аймаг
6. Цэцэн тойны аймаг
7. Андүүгийн аймаг
8. Дашдандарлин аймаг
9. Махасамаяагийн аймаг
10. Пунцагдэгчинлэн буюу Жасын аймаг
11. Номчийн аймаг
12. Сангайн аймаг

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

- 13.Зоогийн аймаг
- 14.Дугарын аймаг
- 15.Чойнхорлин аймаг
- 16.Мэргэн хамбын аймаг
- 17.Бизъяагийн аймаг
- 18.Хүүхэн ноёны аймаг
- 19.Дархан эмчийн аймаг
- 20.Эрхэм тойны аймаг
- 21.Эх дагинын аймаг
- 22.Вангайн аймаг
- 23.Эрдэнэ хувилгааны аймаг
- 24.Баргын аймаг
- 25.Намдоллин аймаг
- 26.Бандидын аймаг
- 27.Жамъян сүнгийн аймаг
- 28.Лам нарын аймаг
- 29.Мэргэн номун ханы аймаг
- 30.Өрлүүдийн аймаг

30 дахь аймаг бол Өрлүүд аймаг. Өрлүүд аймгийн үүссэн түүх нь ийм. Өндөр гэгээний жинхэнэ төрүүлсэн эхээс нь сүү гараагүй. Аягач охин сүүтэй болсон. Өндөр гэгээн аягач охиныг хөхөж өссөн. Тэгээд тэр аягачин нь өрлөг ээж болсон.Өрлөг ээж 30 дахь аймгийг байгуулсан. Өрлөг ээжийн аймаг нь Өрлүүд нэртэй аймаг болсон юм.

Дацангуудын нэрс нь

- 1.Дашчоймбол
- 2.Гунгаачойлин
- 3.Идгаачойндолин
- 4.Бадма-Ёга
- 5.Зурхай
- 6.Жүд
- 7.Дэчингалав
- 8.Нар хажид
- 9.Ногоон сүм
- 10.Жанрайсаг гэсэн 10 дацан байсан.

Манай зиндаанаас Жанчивсэмбэ гэдэг их мундаг эрдэмтэй лам байсан. 2, 3 жилийн өмнө өөд болсон.

Манай зиндааны анги данбо байсан. Сайн лам байсан. Бага байсан болохоор бусад том хүмүүсийг мэдэхгүй

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

байна. Номоо заалгаж уншчихаад ноцолдож тоглоод д явдаг байсан. Зиндаанд нийтдээ 280-аад лам байсан. Одоо хотод Манба дацангийн ловон лам Дагва бид 2 байна. Хөдөө хүмүүс байдаг байхаа.

Гэлэн болж байж гаарамба цолыг авдаг байсан. Чухам хэдэн лам гэлэн сахилтай байсныг мэдэхгүй. Их л олон байсан байх. Хадаг, шидүв, жумбарай юлжин, дондонжу, ог, гом, дом гээд 8 дахь жил дээрээ домын дамжаа барьж байгаа юм. Тэгээд цаашаа 4,5 жил болоод гавжийн дамжаа барина. Гавжийн дамжаа барихгүй бол хөндлөнгийн гаарамбад сурдаг ийм л байсан.

Хийдийн унзад нь Сандаг гэдэг хүн байсан. Шунлайв гэж байсан нэрийг нь санахгүй байна. Шажны долоон цорж гэж байсан. Тэр цорж нар бол дацангуудаар тойрон явж хуралдаа хурдаг байсан. Тиймээс дацанд тусгай цорж гэж байгаагүй юм. Жасын аймгийн Дамдин гэж хүн дэд хамба байсан. Сүүлд нь хуулийн дээд авсан.

Чойжид Равсал гэдэг уншлагыг төгсч байж чойрт ордог ёстой. Аймагтаа аймаглаад хуралдаа хурдаг байсан. Уншлага төгсөөгүй бол дацанд хуруулахгүй. Шалгаж үзээд дацанд авдаг байсан. Одоотой адил хамаагүй хүн авахгүй. Тийм журамтай байсан юм.

Шинийн найманд Ганжуур хурна. Улирал бүр 45 хоногоор хурдаг хурал гэж байсан. Гүнчэ Чон гэж. Өвөлд 45, хаварт 45, зүнд 45 хоног хурна. Цанидын том том судруудыг хурж байгаа юм. Шинийн 29-нд сахиус хурна. Цагаан сарын битүүнд Цэдэр хурна. Цагаан сараар Чоймпрол чог гэж 15 хоног хурна. Бурхан багшийн дүйчэн өдрөөр Ганжуур хурна. Богд ламын дүйчэн өдрөөр мөн ялгаагүй Ганжуур, Улаан юм гэдгийг хурдаг байсан.

Хайлан хурна. Хайланг тусгай санваартай гэлэн гэцлүүд хурна. Дээхнэ үедээ түмэн гэлэнгийн хайлан гэсэн нэртэй байсан гэсэн. Түмэн лам хурдаг байсан. Сүүлдээ тийм олон биш болсон. Хайлангийн дуган гэж тусгай дуган байсан. Одоо Жанрайсагийн сүмийн зүүн талд өндөр шаттай Дэчингалав гэж дуган бий. Тэнд хайлангийн тусгай сүм байсан. Их том тэлүүртэй байсан.

Зүүн хүрээнд Хүрээ цам гэж гардаг байсан. 10 догшид, 10 Хангал: Гомбо, Чойжоо, Лхам, Шалши, Намсрай эд гарна. Дандаа сахиусууд гарна. Хурлын бүжгийг цам гэнэ. Чамбан гэхээрээ тэр цамыг дэглэн, удирдаж тоглуулдаг хүн болно. Зүүн хүрээний цам зуны дунд сард гарч байсан. Одоо манайд тэр хугацаандаа гарч байгаа. Хаврын эхэн сарын 13-нд Майдар эргэдэг байсан. Энэ үеэр сүсэгтнүүд их цуглана. 30 аймаг бүгд нэг нэг шүхэртэй. Жаахан 4 дугуйтай тэрэгтэй. 30 том шүхэр тойроод явдаг байсан. Ганжуурыг Зүүн хүрээний гороог тойроод 4 талд нь 4 үдлээд, судраа мөрөн дээрээ тавиад эргэдэг байсан.

Үздэг номоороо шалгалт шүүлэг өгнө. Гавжийн дамжаа гэдэг чинь 10 бэрх гэсэн үг. 10 жил сүрч байж 10 бэрхийг даваад дамжаа барина гэсэн утгатай юм. Нэг удаад 4 лам 12 хоног дамжаа барьж гавж болно. Гавж гэдэг бол цанидын том цол. Гавж, аграмба, лхаарамба гэсэн 3 том цол бий. Лхаарамба гэдэг нь Лхаст сүрч авдаг тусгай мяндаг. Тарнийн ёсны дээд цолыг аграмба гэдэг. Аграмбууд бол цөөхөн байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гүн ухааны сургалт Банчэн игчаагаар явагддаг байсан. Хадаг, шидүв, жумбарай юлжин, дондонжү, ог, гом, дом, гаарамба гээд 12 зиндаа бүрт түс бүр нэг нэг жил сурна.

Тэр үеийн лам хүний өдөр тутмын амьдрал сайн байсан. Өдөржин номоо үзэж суудаг байсан. Өглөө 5 цаг гээд босно. Би ахыдаа суугаад ном заалгадаг байсан. Хуралдаа хурна. Хуралд боов, бэрээсээ их өгнө. Цав, манж их барина. Лам нарын сахилга бат сайн байсан. Болохгүй зөрчил гаргасан бол хурлаас хөөнө. Гэхдээ сахилга бат сайтай байсан учир хөөгдөх нь их ховор. Хоёр, гурван жилд л нэг тохиолддог байсан. Нэг хөөгдсөн хүн эргэж хийдэд хурахгүй. Тэгээд хөдөө гарч хар болно.

Дашчоймбол дацангийн гол онцлог нь дамжаа барина. Гүн ухааны дацан юм. Тэнд гүн ухаан судална.

Дацан 1937 онд хаагдсан. Хаагдах үед нь би хөдөө байсан. Цэргийн насных байсан учир цэрэгт явж 5 жил алба хаасан. Тэгээд Төв аймгийн Баянчандмань сум, Батсүмбэрийн сангийн аж ахуйд алба ажил хашиж байсан даа. 1991 онд эргээд лам болсон. Шашин бол хуучнаараа сэргэсэн. Монгол улсад Бурханы шашин хөгжихөд номоо л сайн үзэх хэрэгтэй гэж бодож байна. Хар болсны дараа шашин ном сэргээгүй байхад хурал ном хүрж байгаагүй.

Улаанбаатар хотын ойролцоо Шадавлинд даяанч нарын нэг хийд байсан. Дандаа шар орхимжтой лам нар байсан. Дамбадаржаа, Дашчойнхорлин, Шадавлин гэсэн 3 хийд хойно байсан. Дашчойнхорлин гэдэг нь Дамбадаржаагаас хойш нэг толгойн өвөрт байдаг байсан. Одоо юм байхгүй.